



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 26 өдөр

Дугаар A/30

Мөрөн сүм

Мөсөн замын тээвэрлэлтийг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3, 9.4.5, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Захиргааны өрөнхий хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мэргэжлийн байгууллагын хэмжилтээр мөсөн бүрхүүлийн зузаан олон жилийн дунджаас бага, мөсний зузаан харилцан адилгүй зузаантай, зарим гол мөрнүүд харзалсан, нийт уртын дагуу мөсний өөр өөр үзэгдэлтэй байгаа тул холбогдох байгууллагуудын саналыг үндэслэн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах зорилгоор 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн мөсөн дээгүүр авто тээврийн хэрэгслээр зорчихыг хориглосугай.

2. Мөсөн дээгүүр тээвэрлэлт гүйцэтгэхгүй байхыг сумынхаа иргэд, жолооч нарт байнга сэргэжилүүлэн анхааруулж, хяналт шалгалтыг удирдамж, хуваарийн дагуу зохион байгуулж, Онцгой байдлын газар, мэргэжлийн бусад байгууллагуудаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг бүх сумдын Засаг дарга, тосгоны захиррагч нарт даалгасугай.

3. Мөсөн дээгүүр авто тээврийн хэрэгслээр зорчих тээвэрлэлтийн үйл ажиллагааг зогсоож, зохих арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга (хошууч С.Ганболд), аймгийн Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа А.Алтанцоож), Байгаль орчин, аялал, жуулчлалын газрын дарга (П.Мөнхжаргал), Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны дарга (Г.Энхбаяр), Хөвсгөл нуур Эгийн голын сав газрын захиргааны дарга (Д.Эрдэнэболд), Авто тээврийн төвийн дарга (Ө.Баттулга) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийг эс зөвшөөрөл оролцогчдод мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Энэхүү захирамж хэрэгжиж эхлэхтэй холбогдуулж, аймгийн Засаг даргыг 2021 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн "Мөсөн замын тээвэрлэлтийг хориглох тухай" A/27 дугаар захирамжийн үйлчлэлийг зогсоосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6710010086